



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 526

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 184,776,407.84 (нэг зуун наян дөрвөн сая долоон зуун далан зургаан мянга дөрвөн зуун долоон төгрөг наян дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 59,758,318.78 (тавин есөн сая долоон зуун тавин найман мянга гурван зуун арван найман төгрөг далан найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг "Төр хур" амралт, сэргээн засах сувилалд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, бригадын генерал Ц.Амгаланбаяр болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн
586 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА 401 ДҮГЭЭР ХААЛТТАЙ ХОРИХ АНГИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, "ТӨР ХҮР" АМРАЛТ, СЭРГЭЭН ЗАСАХ СУВИЛАЛД БАЛАНСААС
БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон он	Хэмж нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Сувиллын байр	2015	ш	1	66,000,000.00	66,000,000.00	11,831,111.38	54,168,888.62
2	Шалган нэвтрүүлэх байр (3*6)	2011	ш	1	1,000,000.00	1,000,000.00	722,222.62	277,777.38
3	Сауны байр	2011	ш	1	17,485,507.84	17,485,507.84	3,871,790.89	13,613,716.95
4	Хашаа (блокон)	2008	ш	1	74,500,000.00	74,500,000.00	32,034,999.61	42,465,000.39
5	Гүний худаг	2011	ш	1	7,500,000.00	7,500,000.00	4,037,500.00	3,462,500.00
6	Гэр (8 ханатай)	2012	ш	1	7,190,900.00	7,190,900.00	3,036,157.44	4,154,742.56
7	Гэр (4 ханатай)	2012	ш	1	5,000,000.00	5,000,000.00	1,916,666.81	3,083,333.19
8	Гарааш	2011	ш	1	2,000,000.00	2,000,000.00	1,444,444.32	555,555.68
9	Бие засах газар (00, тоосгон)	2011	ш	1	100,000.00	100,000.00	30,092.46	69,907.54
10	Сандал	2016	ш	1	4,000,000.00	4,000,000.00	833,333.25	3,166,666.75
	Нийт дүн					184,776,407.84 (нэг зуун наян дөрвөн сая долоон зуун далан зургаан мянга дөрвөн зуун долоон төгрөг наян дөрвөн мөнгө)	59,758,318.78 (тавин есөн сая долоон зуун тавин найман мянга гурван зуун арван найман төгрөг далан найман мөнгө)	125,018,089.06 (нэг зуун хорин таван сая арван найман мянга наян есөн төгрөг зургаан мөнгө)